

БАТЛАВ:

БАЙГАДЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД

Н.ЦЭРЭНБАТ



“АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРУУЛЫН ХЯНАЛТЫН
360° ЭРГЭДЭГ ГАДАА ЗОРИУЛАЛТЫН АЙ ПИ КАМЕР”
НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт
гэрээний нэр, дугаар: **БОАЖЯ-2019/11/29**

Улаанбаатар хот.
2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРУУЛЫН ХЯНАЛТЫН 360° ЭРГЭДЭГ ГАДАА ЗОРИУЛАЛТЫН АЙ ПИ КАМЕР”-ийг нийлүүлэх үнийн санал авах

Тендер шалгаруулалтын дугаар: БОАЖЯ-2019/11/29

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРУУЛЫН ХЯНАЛТЫН 360° ЭРГЭДЭГ ГАДАА ЗОРИУЛАЛТЫН АЙ ПИ КАМЕР”-ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичиг болон үнийн саналыг **2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 09:00** цагаас өмнө тендерийн материалыг битүүмжлэн хаягийн дагуу ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 09:30** цагт нээнэ.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ,
ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖЛЫН АЛБА**

Монгол улс, Улаанбаатар хот -15160, Нэгдсэн Үндэсний гудамж 5/2,
Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газрын 2-р байр, 3-р давхар
304 тоот Утас 261890

Д.Өнөрбат
Утас: 261890

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|--|------|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| | 2.3. | Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	1. Хуулийн 14.6-д заасанчлан 14.1-д заасан нөхцөл байхгүйг нотлох баримтуудыг 14.3-д зааснаар бичгээр ирүүлнэ. (Татвар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Анхан шатны шүүхийн тодорхойлолтууд) 2. Хуулийн 15.3-д заасан дараах баримт бичгийг нотолсон байна. Үүнд: - Сүүлийн [2] 2017, 2018 оны жилийн санхүүгийн тайлан, аудитын - дүгнэлтийн хамт, - Сүүлийн [2] 2017, 2018 оны жилийн туршлагын мэдээлэл, ижил - төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн гэрээний хуулбарын хамт 3. Нэмэлт шаардлага - Сүүлийн [2] 2017, 2018 оны жилийн борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх; - Байгууллагын танилцуулга ирүүлэх - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх; - Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх; - Нийлүүлэх бараа бүтээгдэхүүний дэлгэрэнгүй танилцуулга болон фото зураг - Үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийн зөвшөөрөл: [шаардлагатай] - Харуулуудыг утасгүй сүлжээний Point-to-Point холболтоор интернетийн үндсэн сүлжээнд холбоход шаардагдах Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөлтэй байх (Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийг хамарна.)
ТӨӨЗ 2.1	<u>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</u> Байгууллагын хаяг: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газрын 2-р байр, 3-р давхар 304 тоот Утас 261890 - Тендерийн материалын эх хувийг хаягийн дагуу ирүүлэх. Давхар болон өрөөний дугаар: БОАЖЯам 3 дугаар давхар, 304 тоот Огноо: 2019 оны 19 дугаар сарын 09-ний өдөр Цаг: 09 цаг 00 минут
ТӨӨЗ 2.2	<u>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</u> Байгууллагын хаяг: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газрын 2-р байр, 3-р давхар 304 тоот Давхар болон өрөөний дугаар: 3 дугаар давхар 304 тоот Огноо: 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Цаг: 09 цаг 30 минут

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ерөнхий шаардлага.

“АЙ ПИ КАМЕР” нь дараах техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Гадаад орчны цаг агаарын үзэгдэл, агаарын чанарыг хянах, ажиглах зориулалтаар гадаад орчинд суурилуулахад тохирсон, өндөр нягтаршилтай, сүлжээний орчинд дүрсээ дамжуулах боломжтой, олон улсын стандарт шаардлагыг хангасан, шинэ, өмнө нь ашиглагдаагүй, сайн чанарын камеруудыг Улаанбаатар хотын агаарын чанарын хяналтын 5 цэг /Баянхошуу, Зурагт, Нисэх, Амгалан, Монгол газар/-т суурилуулах.

Хяналтын цэгүүдийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цаг уур орчны шинжилгээний газрын сүлжээнд холбож, хяналтын цэгүүд дээрх камеруудыг хянах.

Хяналтын цэгүүд нь утасгүй сүлжээний Point-to-Point холболтоор интернетийн сүлжээнд холбогдоно. Уг сүлжээгээр дамжин VPN холболтоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цаг уур, орчны шинжилгээний газрын сүлжээтэй холбогдон камерын дүрсээ дамжуулна.

Тусгай зөвшөөрөл: Харуулуудыг утасгүй сүлжээний Point-to-Point холболтоор интернетийн үндсэн сүлжээнд холбоход шаардагдах Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөлтэй байх (Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийг хамарна.)

№	Үзүүлэлт	Нийлүүлэх тоо ширхэг
АЙ ПИ камерын систем		
1	Гадаа байрлах АйПи Камер (IP Camera) - Full HD 4MP (1920*1080) болон түүнээс дээш - Optical Zoom 12X болон түүнээс дээш - Image Sensor 1/3" Progressive Scan CMOS - Min. Illumination Color: 0.002Lux @F1.2, B/W: 0Lux with IR on - Super WDR 120dB - Shutter Time 1/100000s~1/5s - Day&Night ICR Filter Auto Switch - Focal Length 5.3~64mm 12x AF Lens, Zoom speed 3.1s - Field of View H57°~H4°/D65°~D5°/V35°~V2°(Wide-Tele) - Aperture F1.6-F2.8 - Pan Range 360°endless - Tilt Range -45°~30° - IR 100m - Video Compression H.265+/ H.265(HEVC)/ H.264/ MJPEG - Video Bit Rate 16Kbps~16Mbps (CBR/VBR adjustable) - Audio Compression G.711/AAC - NAS (Support NFS, SMB/CIFS) - Advanced function: Motion Detection, Privacy Masking, Backlight Compensation, HLC, 3D-DNR, ROI, Anti-fog; - Weather Proof IP66-rated for weather-resistant performance - DC 12V, 2A / PoE (802.3at) - Power Consumption 11.5W/15.5W (IR on) max - Гадаа орчинд буюу -40°C ~ +50°C ажиллах боломжтой - Гадна орчинд ашиглах сүлжээний утас /100 метрээс багагүй/ - Камерын холболтын хайрцагтай байх - Камерын баганад бэхлэгчтэй байх - Камер бэхлэх багана - Баталгаат хугацаа 1 жил	5ш

2	Хяналтын камерын бичигч төхөөрөмж (NVR) - 4K H.265+ PoE NVR - 4x PoE ports - 1x Gigabit LAN - 2x USB 2.0 - Recording resolution: 8MP/ 6MP/ 5MP/ 4MP/ 3MP/ 1080P/ UXGA/ 720P/ D1/ VGA/ CIF/ QCIF - 4TB Surveillance HDD 3.5" түүнээс дээш хадгалах төхөөрөмжтэй, нэмэх боломжтой байх - IP Camera Input 4 channel with 1080p Realtime Live View болон түүнээс олон channel-тай байх - Video Resolution: 2560Ч1920, 2048Ч1536, 1920 x 1080, 1280 x 1024, 1280 x 720, 1024 x 768 - Video Recording: Max 80 Mbps - Video Display Split: 1/4 - H.264/MJPEG dual codec decoding - Up to 2MP resolution preview&playback - Recording Mode: Manual, Schedule(Regular(Continuous), MD, Alarm), Stop - Search Mode: Time/Date, Alarm, MD & Exact search (accurate to second), Smart search - Playback: Play, Pause, Stop, Rewind, Fast play, Slow play, Next file, Previous file, Next camera, Previous camera, Full screen, Repeat, Shuffle, Backup selection,Digital zoom - Backup Mode: USB Device / Internal SATA burner/ Network - Interface Ports: 1 HDMI, 1 VGA, 2 USB2.0, 1 RJ45 - Record Interval: 1~120 min (default: 60 min), Pre-record: 1~30 sec, Post-record: 10~300 sec - HDMI / VGA simultaneous video output - Support Multi-brand network cameras - ONVIF Version 2.3 conformance, 4 Ports PoE - User Interface: GUI - Trigger Events: Recording, PTZ, Tour, Alarm, Video Push, Email, FTP, Spot, Buzzer & Screen - Protocols: HTTP, TCP/IP, IPv4/IPv6, UPNP, RTSP, UDP, SMTP, NTP, DHCP, DNS, IP Filter,PPPOE, DDNS, FTP, Alarm Server,ONVIF Version 2.3 - Ethernet: 1 RJ-45 port (10/100M/1000M) - Power Supply: DC12V/2A - Power Consumption: NVR: 10W(without HDD) - Working Temp: -10 ~+55°C / 10~90%RH / 86~106kpa - Баталгаат хугацаа 1 жил	5ш
3	Хяналтын програм - 20 ширхэгээс доошгүй IP камер харах эрх бүхий хугацаагүй license-тэй байна - User-friendly UI design - Support multiple monitors - Support 1/4/8/9/16/36/64 channels playing synchronously - Support the custom live view layout - Support alarm screen for displaying the alarm channel - Support full screen for single or multiple channels - Support H.265/H.264/MJPEG/MPEG -4 video compression - Support dual-stream	2ш

	- Support PTZ control and digital zoom - Support SD card and HDD recording files playback - Support motion detection, alarm recording and image capture functions - Key Features																
Утасгүй сүлжээний Point-to-Point холболтын төхөөрөмж																	
4	Point-to-Point утасгүй сүлжээний төхөөрөмж: - CPU AR9344 - CPU core count 1 - CPU nominal frequency 600 MHz - License level 3 - Operating System RouterOS - Size of RAM 64 MB - Storage size 16 MB - Storage type FLASH - Tested ambient temperature -40°C to 70°C Powering - PoE in Passive PoE - PoE in input Voltage 11-30 V - Number of DC inputs 1 (PoE-IN) - Max power consumption 6 W Wireless - Wireless 5 GHz Max data rate 300 Mbit/s - Wireless 5 GHz number of chains 2 - Wireless 5 GHz standards 802.11a/n - Antenna gain dBi for 5 GHz 24.5 - Wireless 5 GHz chip model AR9344 - Wireless 5 GHz generation Wi-Fi 4 Ethernet - 10/100 Ethernet ports 1 Certification & Approvals - CE/RED, FCC, IC, EAC, ROHS Wireless specifications <table border="0"> <tr> <td>- 5 GHz</td><td>Transmit (dBm)</td><td>Receive Sensitivity</td></tr> <tr> <td>- 6MBit/s</td><td>25</td><td>-96</td></tr> <tr> <td>- 54MBit/s</td><td>20</td><td>-80</td></tr> <tr> <td>- MCS0</td><td>25</td><td>-96</td></tr> <tr> <td>- MCS7</td><td>19</td><td>-75</td></tr> </table> - Баталгаат хугацаа 1 жил	- 5 GHz	Transmit (dBm)	Receive Sensitivity	- 6MBit/s	25	-96	- 54MBit/s	20	-80	- MCS0	25	-96	- MCS7	19	-75	10ш
- 5 GHz	Transmit (dBm)	Receive Sensitivity															
- 6MBit/s	25	-96															
- 54MBit/s	20	-80															
- MCS0	25	-96															
- MCS7	19	-75															
5	Шилэн кабелийн media converter, SFP module Media converter:SPT T1550/R1310,10/100,Single mode Jumper cable Fiber Patch Cord:LC-SC,Single Mode,Simplex, 3m Баталгаат хугацаа 1 жил	5ш															
Интернет болон хяналтын төхөөрөмж																	
6	Суурин харуулуудын интернет сүлжээний урсгал зардал /Бүтэн жилийн эрхтэйгээр, хязгааргүй дататай/	5ш															
7	Гадаад IP хаяг /1 жилийн төлбөр/	5ш															
8	55" инчийн хэмжээтэй PC-тэй холбогдох боломжтой TV дэлгэц Баталгаат хугацаа 1 жил	2ш															
9	Суурин компьютер i7, 8th generation, 8GB ram, 1TBHDD, Graphic card 1GB, Network card 1GB, Windows 10 Үйлдлийн системтэй, хэрэглээний програмнууд суусан, гар, хулгана, 2 дэлгэц холбох боломжтой байх, 23 инчийн LED дэлгэцтэй байх	2ш															

	Баталгаат хугацаа 1 жил	
10	HDMI кабель Урт 10 м-с багагүй байх	2ш
Тоног төхөөрөмжийг харуулуудад суурилуулж, тохиргоог хийх, хяналтын дэлгэцүүдийг холбох, 1 жилийн баталгаат хугацаанд тоног төхөөрөмж болон интернет холболтын хэвийн ажиллагааг ханган ажиллах		

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тооширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Гадаа байрлах АйПи Камер (IP Camera)		5	ш	БОАЖЯ, ОББҮХ	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоног	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 14 хоног	
Хяналтын камерын бичигч төхөөрөмж (NVR)		5	ш				
Хяналтын програм		2	ш				
Point-to-Point утасгүй сүлжээний төхөөрөмж:		10	ш				
Шилэн кабелийн media converter, SFP module Media converter: SPT T1550/R1310, 10/100, Single mode		5	ш				
Jumper cable Fiber Patch Cord: LC-SC, Single Mode, Simplex, 3m		5	ш				
55" инчийн хэмжээтэй PC-тэй холбогдох боломжтой TV дэлгэц		2	ш				
Суурин компьютер i7, 8th generation,		2	ш				

Тав. **ЖИШИГ МАЯГТ**
1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. <i>Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас томилогдсон ажлын хэсэг шалгаж, хүлээж авна.</i> |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн үнийн дүнгийн 40 хүртэлх хувийн урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид олгож болно</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: <i>7 хоногт гэрээний үнийн дүнгийн 0.5 хувь</i></p> <p>Алдангийн нийт дүн: <i>гэрээний үнийн дүнгийн 10%</i></p> |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ____ дугаар сарын ____ -наас _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]